



# “АДУУНЧУЛУУН” ХК

З УЛИРЛЫН ТАЙЛАН

Нүүрсний уурхай

10/25/21

Дорнод аймаг, Хэрлэн  
сүм 8 дугаар баг

# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА



|                                         |                                                                                                                                                                                                          |
|-----------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Компанийн оноосон нэр:                  | “Адуунчулуун” ХК                                                                                                                                                                                         |
| Үйл ажиллагааны чиглэл:                 | Нүүрс олборлох, борлуулах, экспортлох                                                                                                                                                                    |
| Компанийн албан ёсны хаяг:              | Дорнод аймаг, Хэрлэн сум 8-р баг, өөрийн байр                                                                                                                                                            |
|                                         | e-mail: <a href="mailto:info@aduunchuluun.mn">info@aduunchuluun.mn</a>                                                                                                                                   |
|                                         | Санал хүсэлт: <a href="mailto:murun@aduunchuluun.mn">murun@aduunchuluun.mn</a>                                                                                                                           |
| <a href="#">Регистрийн дугаар:</a>      | <a href="#">2011239</a>                                                                                                                                                                                  |
| <a href="#">Улсын бүртгэлийн дугаар</a> | <a href="#">710001008</a>                                                                                                                                                                                |
| Компанийн удирдлага:                    | ТУЗ-ийн дарга Б.Шатар                                                                                                                                                                                    |
|                                         | Гүйцэтгэх захирал Ш.Баясгалан                                                                                                                                                                            |
| Үүсгэн байгуулагдсан огноо:             | 1955 он                                                                                                                                                                                                  |
| Ажилтны тоо:                            | 97                                                                                                                                                                                                       |
| Хувьцааны симбол/код:                   | MSE: ADL/461                                                                                                                                                                                             |
| МХБиржид бүртгэгдсэн:                   | 1995.02.13                                                                                                                                                                                               |
| МХБиржид ангилал:                       | II ангилал                                                                                                                                                                                               |
| Дүрмийн сан:                            | 891,332,700 төгрөг                                                                                                                                                                                       |
| Хувьцааны тоо:                          | 3,151,304 ширхэг энгийн хувьцаа                                                                                                                                                                          |
| Компанийн эрхэм зорилго:                | Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн нүүрс олборлож, борлуулах замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон компанийн ажилтнуудын ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн. |

## “АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН 2021 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компани 2021 оны 3-р улиралд 228.0 мян.тн нүүрс олборлох, 590.0 мян.м<sup>3</sup> хөрс хуулах, нийт 781.6 мян.м<sup>3</sup> уулын цулын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

### 1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2021 оны 3-р улиралд 238.1 мян.тн нүүрс олборлож, төлөвлөснөөс 10.1 мян.тн-р өссөн.


2020 оны мөн үетэй харьцуулбал нүүрс олборлолт биет хэмжээгээр 43.8 мян.тн-р өссөн байна.

| Үзүүлэлт         | Х/нэгж | 2020-III | 2021-III |       | Зөрүү  |       |
|------------------|--------|----------|----------|-------|--------|-------|
|                  |        |          | төлөв    | гүйц  | 2020-с | төл-с |
| Нүүрс борлуулалт | мян.тн | 194.3    | 228.0    | 238.1 | 43.8   | 10.1  |
| “ДБЭХС” ХК       | мян.тн | 186.0    | 211.0    | 219.5 | 33.5   | 8.5   |
| Ахуй             | мян.тн | 8.3      | 17.0     | 18.6  | 10.3   | 1.6   |
| Хөрс хуулалт     | мян.м3 | 638.3    | 590.0    | 617.7 | -20.6  | 27.7  |
| Уулын цул        |        | 801.6    | 781.6    | 817.8 | 16.2   | 36.2  |


“ДБЭХС” ТӨХК-д нүүрс нийлүүлэх төлөвлөгөөг давуулан биелүүлж, ахуйн хэрэглэгчдэд 18.6 мян.тн-ыг нийлүүлж, төлөвлөснөөс 1.6 мян.тн-р өссөн.

Нүүрсний нийт олборлолтын 92.2%-ийг “ДБЭХС” ХК-д, 7.8%-ийг айл өрх, ААНэгжүүдэд борлуулсан.

2017-2021 оны 3-р улирал буюу сүүлийн 5 жилийн байдлаар олборлож борлуулсан нүүрсний хэмжээг дараах графикаар харьцуулж харууллаа. Графикаас харвал 2018 онд “ДБЭХС” ТӨХК-д, айл өрх, албан байгууллагуудад хамгийн их хэмжээгээр борлуулалт хийсэн байна. 2021 онд хийгдсэн борлуулалт 2020 оноос өссөн үзүүлэлттэй харагдаж байна.



2021 оны 5-р сараас хөрс хуулалтын ажил эхэлж төлөвлөгөө ёсоор 590.0 мян.м<sup>3</sup> хөрс хуулахаас 617.7 мян.м<sup>3</sup> хөрс хуулж 27.7 мян.м<sup>3</sup> хөрс илүү хуулсан байна. Дараах графикаар сүүлийн 5 жилийн хөрс хуулалтын хэмжээг харьцуулж харууллаа.



Тайлант хугацаанд уулын цул 817.8 мян.м<sup>3</sup>, өнгөрсөн оны мөн үеэс 16.2 мян.м<sup>3</sup>-р өссөн байна.

## **2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2020 оны бүтэц, орон тоогоор 109 байнгын ажлын байранд 108 ажилтан албан хаагчидтай ажилласан бол тайлант хугацаанд 97 орон тоог баталж 86 ажилтан, албан хаагчтай ажиллаж байна.

Компани нь захиргаа аж ахуй, санхүү төлөвлөлт хангамж борлуулалт гэсэн 2 хэлтэс, уул, автозасвар, цахилгаан сантехник гэсэн 3 хэсэгтэй.

| № | Овог нэр     | Албан тушаал                         |
|---|--------------|--------------------------------------|
| 1 | Ш.Баясгалан  | Гүйцэтгэх захирал                    |
| 2 | Н.Болдрагчаа | Ерөнхий инженер                      |
| 3 | Б.Энхбаатар  | Ерөнхий нягтлан бодогч               |
| 4 | Г.Батжаргал  | ХАБЭА-н инженер                      |
| 5 | Э.Мөнхтөр    | Уулын хэсгийн дарга                  |
| 6 | Г.Баярхүү    | Автозасварын хэсгийн дарга           |
| 7 | Б.Баттөр     | Цахилгаан сантехникийн хэсгийн дарга |

### **Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд**

| № | Овог нэр     | Албан тушаал   |
|---|--------------|----------------|
| 1 | Б.Шатар      | ТУЗ-ийн дарга  |
| 2 | Б.Батсайхан  | ТУЗ-ийн гишүүн |
| 3 | Н.Болдрагчаа | ТУЗ-ийн гишүүн |

|    |              |                              |
|----|--------------|------------------------------|
| 4  | Ш.Баясгалан  | ТУЗ-ийн гишүүн               |
| 5  | Ш.Идэр       | ТУЗ-ийн гишүүн               |
| 6  | Д.Галтогтох  | ТУЗ-ийн гишүүн               |
| 7  | С.Бадарч     | ТУЗ-ийн хараат бус гишүүн    |
| 8  | Н.Энхцэцэг   | ТУЗ-ийн хараат бус гишүүн    |
| 9  | Ө.Амаржаргал | ТУЗ-ийн хараат бус гишүүн    |
| 10 | О.Гангамөрөн | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |

### 3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд нийт 3776.5 сая.төг-ийн орлого орж, 4244.3 сая.төг-ийн зардал гаргаж ажилласан.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал орлого 633.1 сая.төг буюу 20.1 %-иар, харин зардал 307.6 сая.төг буюу 7.8 %-иар тус тус өссөн бол алдагдал -467.8 сая.төгрөг гарч, өнгөрсөн оны мөн үеэс 325.5 сая.төгрөгөөр буурсан байна.

| Үзүүлэлт           | Х/нэгж  | 2020-III | 2021-III | Харьцуулалт |       |
|--------------------|---------|----------|----------|-------------|-------|
|                    |         |          |          | тоо         | %-р   |
| <b>Нийт орлого</b> | сая.төг | 3,143.4  | 3,776.5  | 633.1       | 20.1  |
| <b>Нийт зардал</b> | сая.төг | 3,936.7  | 4,244.3  | 307.6       | 7.8   |
| <b>ТТӨ ашиг</b>    | сая.төг | -793.3   | -467.8   | 325.5       | -41.0 |

#### Орлого:

Тайлант хугацаанд нийт орлого 3776.5 сая.төг, үүнээс нүүрсний орлого 3025.7 сая.төг, тээврийн орлого 615.6 сая.төг, бусад орлого 135.2 сая.төг. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого 633.1 сая.төг-р өссөн.

Нүүрсний орлого дотор ахуйн хэрэглэгчдэд нийлүүлсэн нүүрсний биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 10.3 мян.тн-р, мөнгөн дүнгээр 144.0 сая төгрөгөөр өссөн.

Гол хэрэглэгч болох “ДБЭХС” ТӨХК-д нийлүүлсэн нүүрсний биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 33.5 мян.тн-р, мөнгөн дүнгээр 422.1 сая төгрөгөөр өссөн.

Тээврийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 93.6 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Бусад орлого өнгөрсөн оны мөн үеэс 26.6 сая төгрөгөөр буурсан байна.

| Орлого                     | Х/нэгж  | 2020-III | 2021-III | Харьцуулалт |       |
|----------------------------|---------|----------|----------|-------------|-------|
|                            |         |          |          | тоо         | %     |
| <b>Нүүрсний борлуулалт</b> | сая.төг | 2,459.6  | 3,025.7  | 566.1       | 23.0  |
| <b>Станц</b>               | сая.төг | 2,343.6  | 2,765.7  | 422.1       | 18.0  |
| <b>Ахуй</b>                | сая.төг | 116.0    | 260.0    | 144.0       | 124.1 |

|                        |                |                       |                       |                     |                    |
|------------------------|----------------|-----------------------|-----------------------|---------------------|--------------------|
| <b>Тээврийн орлого</b> | сая.төг        | 522.0                 | 615.6                 | 93.6                | 17.9               |
| <b>Бусад орлого</b>    | сая.төг        | 161.8                 | 135.2                 | -26.6               | -16.5              |
| <b>Нийт</b>            | <b>сая.төг</b> | <b><u>3,143.4</u></b> | <b><u>3,776.5</u></b> | <b><u>633.1</u></b> | <b><u>20.1</u></b> |

### **Зардал:**

Тайлант хугацаанд нийт 4244.3 сая.төг-ийн зардал гаргаж ажилласнаас үндсэн үйлдвэрлэлд 3649.9 сая.төг, ТУЗ, удирдлагын зардалд 386.8 сая.төг, үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаанд 207.6 сая.төг зарцуулсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зардал 307.6 сая төгрөгөөр өссөн. Үүнд үндсэн үйлдвэрлэлийн зардал 353.3 сая төгрөгөөр өсч, удирдлагын зардал 35.1 сая төгрөгөөр буурч, үйл ажиллагааны бус зардал 10.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.


Дараах хүснэгтэнд нийт зардлыг төрлөөр нь задалж харуулав.

| №  | Зардлын үзүүлэлт           | Х/нэгж  | 2020-III | 2021-III | Зөрүү | Зардалд эзлэх хувь | Тайлбар                                                                                                                            |
|----|----------------------------|---------|----------|----------|-------|--------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1  | Үндсэн ба нэмэгдэл цалин   | сая.төг | 1057.6   | 1092.3   | 34.7  | 29.9               | 2020 оны 4 сараас захиргааны бүх ажилчдын цалин энэ хэсгийн цалингийн зардалд ордог болсон нь цалингийн зардал өсөх нөхцөл болсон. |
| 2  | Нийгмийн даатгалын шимтгэл | сая.төг | 162.5    | 171.8    | 9.3   | 4.7                |                                                                                                                                    |
| 3  | Сэлбэг                     | сая.төг | 440.3    | 401.0    | -39.3 | 11.0               |                                                                                                                                    |
| 4  | Түлш                       | сая.төг | 338.7    | 355.7    | 17.0  | 9.7                |                                                                                                                                    |
| 5  | Бензин                     | сая.төг | 27.7     | 32.5     | 4.8   | 0.9                |                                                                                                                                    |
| 6  | ШТМатериал                 | сая.төг | 75.1     | 69.7     | -5.4  | 1.9                |                                                                                                                                    |
| 7  | Цахилгаан                  | сая.төг | 234.5    | 278.2    | 43.7  | 7.6                | Нүүрс олборлот өмнөх оноос 43,8 мянган тонноор өссөн нь цахилгааны зардал өссөн.                                                   |
| 8  | Дулаан                     | сая.төг | 5.5      | 8.2      | 2.7   | 0.2                |                                                                                                                                    |
| 9  | Ус                         | сая.төг | 10.0     | 9.7      | -0.3  | 0.3                |                                                                                                                                    |
| 10 | Урсгал засвар              | сая.төг | 79.0     | 151.5    | 72.5  | 4.1                | ЭКГ№8690 засварт 19.9 сая төг, Титэм хийц ХХК-с ф-100 труба 54 м, ф-76 труба 150 м, бутлуурын шигшүүрийн засварт 16.8 сая төг,     |
| 11 | Хөдөлмөр хамгаалал ХМате   | сая.төг | 43.1     | 52.3     | 9.2   | 1.4                |                                                                                                                                    |
| 12 | Барилгын материал          | сая.төг | 3.6      | 0.0      | -3.6  | 0.0                |                                                                                                                                    |
| 13 | Газар ашиглалт түрээс      | сая.төг | 43.7     | 60.2     | 16.5  | 1.6                |                                                                                                                                    |
| 14 | Байгал орчин нөхөн сэргээх | сая.төг | 58.6     | 46.7     | -11.9 | 1.3                |                                                                                                                                    |
| 15 | Даатгал                    | сая.төг | 5.1      | 7.7      | 2.6   | 0.2                |                                                                                                                                    |



|    |                               |         |               |               |              |              |                                                                                                                                                                                   |
|----|-------------------------------|---------|---------------|---------------|--------------|--------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 16 | Тээврийн зардал               | сая.төг | 5.8           | 14.2          | 8.4          | 0.4          |                                                                                                                                                                                   |
| 17 | Газрын төлбөр                 | сая.төг | 24.7          | 21.4          | -3.3         | 0.6          |                                                                                                                                                                                   |
| 18 | АМНАТөлбөр                    | сая.төг | 61.5          | 75.6          | 14.1         | 2.1          |                                                                                                                                                                                   |
| 19 | Тээврийн хэрэгслийн татвар    | сая.төг | 2.9           | 2.2           | -0.7         | 0.1          |                                                                                                                                                                                   |
| 20 | Үл хөдлөх хөрөнгийн татвар    | сая.төг | 17.9          | 13.1          | -4.8         | 0.4          |                                                                                                                                                                                   |
| 21 | Албан томилолт                | сая.төг | 11.1          | 7.3           | -3.8         | 0.2          |                                                                                                                                                                                   |
| 22 | Бичиг хэрэг                   | сая.төг | 2.5           | 2.0           | -0.5         | 0.1          |                                                                                                                                                                                   |
| 23 | Сургалт                       | сая.төг | 3.4           | 1.7           | -1.7         | 0.0          |                                                                                                                                                                                   |
| 24 | Холбоо                        | сая.төг | 5.4           | 4.5           | -0.9         | 0.1          |                                                                                                                                                                                   |
| 25 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил    | сая.төг | 31.8          | 34.2          | 2.4          | 0.9          |                                                                                                                                                                                   |
| 26 | Гэрээт харуул хамгаалалт      | сая.төг | 63.3          | 61.9          | -1.4         | 1.7          |                                                                                                                                                                                   |
| 27 | Үндсэн хөрөнгийн элэгдэл      | сая.төг | 432.2         | 367.2         | -65.0        | 10.1         |                                                                                                                                                                                   |
| 28 | Банкны зээлийн хүү            | сая.төг | 22.4          | 59.6          | 37.2         | 1.6          |                                                                                                                                                                                   |
| 29 | Бусад зардал                  | сая.төг | 26.7          | 248.0         | 221.3        | 6.8          | Б.Баярцогт-25.1 сая, Ю.Лутбаатар-14.8 сая, Д.Энхдаваа-16.3 сая төг-ийн тэтгэмж олгосон байна. COVID-19 өвчлөлттэй тэмцэхэд-АОК-д 10 сая төг, Хэрлэн суманд 5 сая төг хандивласан. |
|    | <b>Үйл ажиллагааны зардал</b> | сая.төг | <b>3296.6</b> | <b>3649.9</b> | <b>353.4</b> | <b>100.0</b> |                                                                                                                                                                                   |
| 30 | ТУЗ/Удирдлага                 | сая.төг | 421.9         | 386.8         | -35.1        |              |                                                                                                                                                                                   |
| 31 | Үйл ажиллагааны бус зардал    | сая.төг | 218.3         | 207.6         | -10.7        |              |                                                                                                                                                                                   |
|    | <b>Бүрэн өөрийн өртөг</b>     | сая.төг | <b>3936.7</b> | <b>4244.3</b> | <b>307.6</b> |              |                                                                                                                                                                                   |

Үйл ажиллагааны зардал дотор цалин 29.9%, элэгдэл 10.1%, сэлбэг 11%, түлш 9.7%, бусад зардал 58.7%-ийг тус тус эзэлж байна.



#### Үйл ажиллагааны нэгжийн өртөг:

| Үзүүлэлт            | Хэмжих нэгж | 2020-III | 2021-III | Зөрүү    |
|---------------------|-------------|----------|----------|----------|
| Нүүрс олборлолт     | тн          | 194.3    | 238.1    | 43.8     |
| Бүрэн өөрийн өртөг  | төг         | 3936.7   | 4244.3   | 307.6    |
| 1 тн нүүрсний өртөг | төг         | 20,260.9 | 17,825.7 | -2,435.2 |

1 тн нүүрсний өртөг 2020 оны 3-р улиралд 20260.9 төгрөг байсан бол тайлант хугацаанд 17825.7 төгрөг болж 2435.2 төгрөгөөр буурсан.

#### 4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО: **3 151 304**

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО: **1163**

/2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар/

Компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн талаарх мэдээлэл

| № | Овог нэр         | Эзэмшиж буй хувьцаа |
|---|------------------|---------------------|
| 1 | Б.Шатар          | 51%                 |
| 2 | “Адуунчулуун” ХК | 18%                 |
| 3 | Ш.Бямбасүрэн     | 18%                 |
| 4 | Бусад            | 13%                 |

#### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, компанийн өөрийн байранд 14:00 цагт 2 182 268 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84,5 хувийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах
4. ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг батлах
5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

#### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 3 дугаар улиралд цар тахал (Covid-19)-ын нөхцөл байдлын улмаас шалтгаалан 1 удаагийн ээлжит хурлыг хийж дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:



1. 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцах
2. Гүйцэтгэх захирлын гэрээг батлах
3. Хороодын төлөвлөгөөтэй танилцаж батлах

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА ХУВЬЦАА

2021/01/01-2021/09/30 хувьцааны ханш, арилжаа



Эх сурвалж: <http://mse.mn/mn/company/461>

## ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

| Үзүүлэлт                     | 2021.06.30     | 2021.09.30 |
|------------------------------|----------------|------------|
| Хувьцааны төрөл              | Энгийн хувьцаа |            |
| Хувьцааны үнэ /төгрөг/       | 900            | 901.7      |
| Хаалтын үнэ                  | 900            | 901.7      |
| Хамгийн их үнэ               | 1000           | 1000       |
| Хамгийн бага үнэ             | 800            | 777        |
| Дундаж үнэ                   | 915.6          | 902        |
| Арилжаалагдсан тоо /ширхэг/  | 19,083         | 25,651     |
| Арилжааны үнийн дүн /төгрөг/ | 17,401,877     | 23,126,286 |

## 5. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компани нэгж хувьцаанд 40 төгрөг хуваарилах шийдвэр гаргаж 98,0 сая төгрөгийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдөр 100 хувь байршуулсан.

| Код | Компанийн нэр | Бүртгэх өдөр | Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг /төг/ | ХЭ-ийн тоо | Хувьцааны тоо | Дансанд байршуулсан ногдол ашиг /төг/ |
|-----|---------------|--------------|------------------------------------------|------------|---------------|---------------------------------------|
|-----|---------------|--------------|------------------------------------------|------------|---------------|---------------------------------------|

|     |                          |            |     |       |           |                 |
|-----|--------------------------|------------|-----|-------|-----------|-----------------|
| 461 | “АДУУНЧУЛУУН”ХК<br>(ADL) | 2021.04.05 | 38₮ | 1,162 | 2,584,049 | 98,021,390.00 ₮ |
|-----|--------------------------|------------|-----|-------|-----------|-----------------|

“АДУУНЧУЛУУН” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... /Ш.БАЯСГАЛАН/

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

..... /О.ГАНГАМӨРӨН/